| 1 | Гадаад байдал | Шинэ бүтэн, цэвэр гадны үнэр, амтгүй байна. Толгой нь нягтарсан байна. |
| 2 | Өнгө | Цайвар ногоон |
| 3 | Ишний урт, см дээшгүй | 3 |
| 4 | Гэмтлийн хэмжээ | Гадна талын 1 навч шалбарсан байж болно бусад бүх гэмтлийг хүлээн зөвшөөрөхгүй |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-3 ГУРИЛ - /1-Р ГУРИЛ/

Тоо хэмжээ: 10,000 кг.

| | | |
|---|---|---|
| 1. | Стандарт | *Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0244:2009* |
| 2. | Барааны ерөнхий шинж чанар | *БГТ-075, БГТ-075 ангиллын гурил байх бөгөөд өнгө, үнслэг, ширхэгжилтийн хэмжээ, цавуулгийн тоо, чанарын үзүүлэлтээр талх, үндэсний гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэнэ.*<br>*Өнгө: Цагаан буюу шаравтар туяатай цагаан*<br>*Үнэр: Буудайн гурилын хэвийн үнэртэй, исгэлэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй байна.*<br>*Амт: Буудайн гурилын хэвийн амттай, исгэлэн гашуун, чихэрлэг амтгүй байна.*<br>*Эрдэс хольц: Зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл зажлагдахгүй байна.* |
| 3. | Физик, химийн шинж чанар | *Чийглэг 15-15,5% ихгүй, үнслэг 0,75-0,85%-иас ихгүй, ширхэгжилт, үлдэц 2-3,0%-иас ихгүй, капрон шигшүүрийн дугаар 38, микрон 180, нойтон цавуулгийн хэмжээ 26,0-30%-иас багагүй, цавуулгийн чанар 20-100 нэгж, ИДК-1-ийн заалт, бүлгээр II доошгүй, хүчиллэг 4,00Н, тосны хүчлийн тоо 30мг/100г ихгүй, төмөрлөг хольц 3мг/кг, Уналтын тоо 200-300 сек багагүй, 100 г гурилын туршилтын хэвтэй талхны эзэлхүүн 500см3 байна.* |
| 4. | Савалгаа /кг/ | *Гурилыг "Гурилын шуудай MNS 2515:1994"-ийн шаардлага хангасан шуудай, уутанд 10 кг, 20 кг, 50 кг хүртэл жинтэйгээр жижиглэн савлаж, амсрыг битүүмжилсэн байх.* |
| 5. | Сав, баглаа, боодол | *"Гурилын шуудай MNS 2515:1994"-ийн шаардлага хангасан шуудай байна. Савласан гурилын жингийн хэлбэлзэл ± 1,0 %-иас ихгүй байна.*<br>*Гурилын тухайн үеийн чийглэгийн хэмжээнээс хамааруулан чийглэгийн зөрүүгээр жингийн нэмэгдэл, хорогдлыг тооцно.* |
| 6. | Шошго, хаяглалт | *Савласан гурилын шуудай, уут бүр нь "Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгонтонд тавих ерөнхий шаардлага" MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:*<br>*„ барааны тэмдэг ба үйлдвэрлэгчийн нэр хаяг;*<br>*„ бүтээгдэхүүний нэр, ангилал;*<br>*„ бүтээгдэхүүний цэвэр жин;*<br>*„ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;*<br>*„ найрлага, илчлэг чанар;*<br>*„ хадгалах хугацаа;*<br>*„ хадгалах нөхцөл;* |

| | | |
|---|---|---|
| | | *„ стандартын дугаар, тэмдэглэгээ.* |
| 7. | Дүгнэлт, шалгалт | *Буудайн гурилын чанар, аюулгүй байдал нь "Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0244:2009" стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх* |
| 8. | Хадгалалт, Тээвэрлэлт | *8 8.1 Буудайн гурилыг агаарын солилцоо сайтай, 15 0С"иас дээшгүй температуртай, 60 %-иас дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй, хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв өвөрмөц үнэргүй, шороо чийгээс бүрэн хамгаалсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж эсвэл бункерт задгайгаар хадгалсан байх.*<br><br>*8.2 Гурилыг үйлдвэрлэсэн өдрөөс хойш нэг жилээс дээшгүй хугацаагаар хадгална.*<br><br>*8.3 Буудайн гурилыг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй байна.*<br><br>*8.4 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ.* |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-3 ГОЙМОН

Тоо хэмжээ: 1,500 кг.

| | | |
|---|---|---|
| 1. | Стандарт | *Гоймон. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0142:1985* |
| 2. | Барааны ерөнхий шинж чанар | *улаан буудайн гоймонгийн зориулалттай гурилаар хийгдсэн. Хөндий, нарийн, дүрслэг хэлбэрийн гоймон байх ба.*<br>*Өнгө:Хэрэглэж буй гурилын өнгөнд тохирсон шаргал буюу цайвар шаргал туяатай жигд өнгөтэй байна.*<br>*Гадаад байдал: Шахаж хэвлэсэн гоймонгийн гадаргуу гөлгөр, Зүсмэл гоймонгийн гадаргуу гөлгөр биш байж болно.*<br>*Хэлбэр дүрс: Нэр төрөлдөө тохирсон зөв хэлбэр дүрстэй байна. Урт дунд хэрчилттэй хөндий, нарийн, туузан гоймонд бага зэрэг муруй тахир байхыг зөвшөөрнө. Богино хэрчилттэй гоймон муруй тахир байж болно.*<br>*Амт, үнэр: Нэр төрөл, ангилалдаа тохирсон амт үнэртэй, хөгцөрсөн гашуун исгэлэн буюу гадны үнэр амтгүй байна.*<br>*Биет байдал: Гүйцэд болтол чанах явцад хэлбэр дүрсээ алдахгүй, хөндий гоймон нь заадсаараа задарч салахгүй хоорондоо бөөгнөрөөгүй байна.* |
| 3. | Физик, химийн шинж чанар | *Чийглэг 14-15,5% ихгүй, хүчиллэг 4 градусаас ихгүй, төмөрлөг хольц кг-д 3 мг-аас ихгүй* |
| 4. | Савалгаа /кг/ | *Гоймонг шаардлага хангасан шуудай, уутанд 10кг-25кг хүртэл жинтэйгээр жижиглэн савлаж, амсрыг битүүмжилсэн байх.* |
| 5. | Сав, баглаа, боодол | “Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны ямар нэг бодис агуулаагүй, гадны үнэр, амтыг нэвтрүүлэхгүй байх. Хэрэв шуудайнд савласан бол уг шуудай нь бат бөх, цэвэр байх. |
| 6. | Шошго, хаяглалт | *Савласан гуоймонгийн шуудай, уут бүр нь “Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгoлтонд тавих ерөнхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:*<br>*„ барааны тэмдэг ба үйлдвэрлэгчийн нэр хаяг;*<br>*„ бүтээгдэхүүний нэр, ангилал;*<br>*„ бүтээгдэхүүний цэвэр жин;*<br>*„ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;*<br>*„ найрлага, илчлэг чанар;*<br>*„ хадгалах хугацаа;* |

| | | |
|---|---|---|
| | | *„ хадгалах нөхцөл;*<br><br>*„ стандартын дугаар, тэмдэглэгээ.* |
| 7. | Дүгнэлт, шалгалт | *Гоймон. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0142:1985 стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх* |
| 8. | Хадгалалт, Тээвэрлэлт | Гоймонг хортон мэрэгчгүй цэвэр хуурай +30⁰С-ээс ихгүй температурт, 70%-иас дээшгүй агаарын харьцангүй чийглэгтэй агуулахад шалнаас 20 см-ийн өндөрт зориулалтын тавцан дээр хананаас 50 см-ийн зайтай хурааж хадгална.<br><br>Гоймонг гадны өвөрмөц үнэртэй буюу хортой зүйлийн хамт хадгалахыг хориглоно.<br><br>Гоймонг бүх төрлийн тээврээр ус, шорооноос хамгаалан тээвэрлэнэ.<br><br>Өвөрмөц үнэртэй болон хортой зүйл тээвэрлэсэн тээврийн хэрэгсэлд цэвэрлэлгүйгээр гоймон тээвэрлэхийг хориглоно.<br><br>Хөндий, нарийн, туузан, дүрслэг гоймонг хадгалах хугацаа нэг жил байна. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.
Багц-3 ХҮҮХДИЙН БУДАА
Тоо хэмжээ: 523,75 кг.

| | | |
|---|---|---|
| 1. | Стандарт | "Хүүхдийн будаа. Техникийн шаардлага: MNS 0243 - 2003 3 х стандарт |
| 2. | Барааны ерөнхий шинж чанар | Исгэлэн, гашуун, хөгц зэрэг бусад гадны өнгө үнэр амтгүй, шүдэнд мэдрэгдэх элсэрхэг хатуу зүйлгүй байна. |
| 3. | Дүгнэлт, шалгалт | Хүүхдийн будааны чанар, аюулгүй байдал нь "Хүүхдийн будаа. Техникийн шаардлага: MNS-0243-2003" стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх |
| 4. | Хадгалалт, Тээвэрлэлт | 4.1 Хүүхдийн будааг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байна.<br>4.2 Хүүхдийн будааг агаарын солоилцоо сайтай -5$^0$С-аас дээшгүй дулаантай 60м дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв үнэргүй, нар шороо чийгнээс бүрэн хамгаалагдсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална<br>4.3 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ. |

Багц-3 ШАР БУДАА
Тоо хэмжээ: 500 кг.

Дээж ирүүлэх: Бүтээгдэхүүний дээжийг нийлүүлэх үйлдвэрийн савалгаатайгаар ирүүлнэ.

| | | |
|---|---|---|
| 1. | Стандарт | "Шар будаа. Техникийн шаардлага: MNS 0533 : 1998 2 х стандарт |
| 2. | Барааны ерөнхий шинж чанар | Исгэлэн, гашуун, хөгц зэрэг бусад гадны өнгө үнэр амтгүй, шүдэнд мэдрэгдэх элсэрхэг хатуу зүйлгүй байна. |
| 3. | Дүгнэлт, шалгалт | Шар будааны чанар, аюулгүй байдал нь "Шар будаа. Техникийн шаардлага: MNS 0533 : 1998" стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх |
| 4. | Хадгалалт, Тээвэрлэлт | 4.1 Шар будааг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байна.<br>4.2 Шар будааг агаарын солоилцоо сайтай -5$^0$С-аас дээшгүй дулаантай 60м дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв үнэргүй, нар шороо чийгнээс бүрэн хамгаалагдсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална<br>4.3 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-3 ЦАГААН БУДАА

Тоо хэмжээ: 6,500 кг.

| | | |
|---|---|---|
| 1. | Стандарт | "Цагаан будаа. Техникийн шаардлага: MNS ISO 7301:2000" стандарт |
| 2. | Барааны ерөнхий шинж чанар | Өнгөлсөн цагаан будаа: Хальсалсан цагаан будаанаас үр болон хивэгийг цэвэрлэж, өнгөлсний дараах цагаа будаа байна.<br>Өнгөлсөн цагаан будааны бүтэн болон эвдэрсэн үр нь гадны ямар нэг үнэргүй, цэвэр, сайн чанартай байна. |
| 3. | Физик, химийн шинж чанар | Чийг 15%-иас ихгүй, гадны хольц органик 0,5%, органик бус 0,5%, тутарга 2,5%, хальсалсан цагаан будаа 1,0%, халуун боловсруулалтад гэмтсэн үр 3,0%, гэмтсэн үр 3,0%, гүйцэт боловсроогүй үр 2,0%, гуриланцар үр 11,0%, улаан үр 4,0%, улаан судалт үр 8,0%, амилопектинжсэн цагаан будаа 1,0% байх |
| 4. | Савалгаа /кг/ | Цагаан будааг стандартын шаардлага хангасан уут, шуудайд савлаж, амсарыг битүүмжилсэн байх. /25кг/ |
| 5. | Сав, баглаа, боодол | Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны ямар нэг бодис агуулаагүй, гадны үнэр, амтыг нэвтрүүлэхгүй байх. Хэрэв шуудайнд савласан бол уг шуудай нь бат бөх, цэвэр байх. |
| 6. | Шошго, хаяглалт | Савласан будааны уут, шуудай бүр нь "Савласан хүнсний бүтээгдэхүүний шошголтонд тавих ерөнхий шаардлага" MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:<br>„ үйлдвэрлэгчийн нэр хаяг, ялгах тэмдэг;<br>„ бүтээгдэхүүний нэр, зэрэг, дугаар;<br>„ бүтээгдэхүүний цэвэр жин, кг-аар;<br>„ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;<br>„ хадгалах хугацаа;<br>„ хадгалах нөхцөл;<br>„ стандартын дугаар, тэмдэглэгээ. |
| 7. | Дүгнэлт, шалгалт | Цагаан будааны чанар, аюулгүй байдал нь "Цагаан будаа. Техникийн шаардлага: MNS ISO 7301:2000" стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх |

| | | |
|---|---|---|
| 8. | Хадгалалт, Тээвэрлэлт | 8.1 Цагаан будааг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байна.<br>8.2 Цагаан будааг хуурай, цэвэр, хортон шавьжаар бохирдоогүй, агааржуулалт сайтай, ариун цэврийн шаардлага хангасан агуулахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сараас дээшгүй хугацаагаар хадгална.<br>8.3 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.
БАГЦ-3 ЭЛСЭН ЧИХЭР
Тоо хэмжээ: 2000 кг

| № | СТАНДАРТ | ЭЛСЭН ЧИХЭР MNS CAC 212 – 2014 |
|---|---|---|
| 1 | Барааны ерөнхий шинж чанар | Жигд нарийн ширхэгтэй, цагаан өнгөтэй, уусмал нь тунгалаг өнгөтэй байна. Өөрийн төрлийн үнэртэй, өөрийн төрлийн чихэрдэг амттай, уусалт сайн, нэр төрөлдөө тохирсон хэлбэртэй байна. Гадны хольцгүй байна. |
| 2 | Савалгаа | Элсэн чихрийг стандартын шаардлага хангасан уут, шуудайд савлаж, амсарыг битүүмжилсэн байх. /10-25кг/ |
| 3 | Сав, баглаа, боодол | Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны ямар нэг бодис агуулаагүй, гадны үнэр, амтыг нэвтрүүлэхгүй байх. Хэрэв шуудайнд савласан бол уг шуудай нь бат бөх, цэвэр байх. |
| 4. | Шошго, хаяглалт | Савласан элсэн чихрийн уут, шуудай бүр нь “Савласан хүнсний бүтээгдэхүүний шошголтонд тавих ерөнхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:<br>„ үйлдвэрлэгчийн нэр хаяг, ялгах тэмдэг;<br>„ бүтээгдэхүүний нэр, зэрэг, дугаар;<br>„ бүтээгдэхүүний цэвэр жин, кг-аар;<br>„ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;<br>„ хадгалах хугацаа;<br>„ хадгалах нөхцөл;<br>„ стандартын дугаар, тэмдэглэгээ. |
| 5 | Дүгнэлт, шалгалт | Элсэн чихрийн чанар, аюулгүй байдал нь “Элсэн чихэр: MNS CAC 212 - 2014” стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх |
| 6 | Хадгалалт, Тээвэрлэлт | 6.1 Элсэн чихрийг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байна.<br>6.2 Элсэн чихрийг агаарын солоилцоо сайтай -5$^0$С"аас дээшгүй дулаантай 60-м дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв үнэргүй, нар шороо чийгнээс бүрэн хамгаалагдсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална<br>6.3 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.
Багц№3 УРГАМЛЫН ТОС
Тоо хэмжээ: 1800 л

| № | СТАНДАРТ | Ургамлын тос MNS6646:2016 |
|---|---|---|
| 1 | Барааны ерөнхий шинж чанар | Цэвэршүүлсэн, шилмэл, тунадасгүй, тунгалаг, үнэргүй, нэр төрөлдөө тохирсон амттай. |
| 2 | Сав, баглаа, боодол | Ургамлын гаралтай хүнсний тосыг төрөл бүрийн хэлбэр дүрстэй 1-20 хүртэл литрийн багтаамж бүхий зориулалтын шилэн, хуванцар материал/PET/PETE/-аар хийсэн лонх, саванд савлана. |
| 3 | Шошго, хаяглалт | Үүнд:<br>„ үйлдвэрлэгчийн нэр хаяг, ялгах тэмдэг;<br>„ бүтээгдэхүүний нэр, зэрэг, дугаар;<br>„ бүтээгдэхүүний цэвэр жин, л-ээр;<br>„ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;<br>„ хадгалах хугацаа;<br>„ хадгалах нөхцөл;<br>„ стандартын дугаар, тэмдэглэгээ. |
| 4 | Дүгнэлт, шалгалт | Ургамлын тосны чанар, аюулгүй байдал нь “Ургамлын тос MNS6646:2016” стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх |
| 5 | Хадгалалт, Тээвэрлэлт | 5.1 Ургамлын тос зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байна.<br>5.2 Ургамлын тосыг агаарын солоилцоо сайтай -5$^0$С “аас дээшгүй дулаантай 60 м дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв үнэргүй, нар шороо чийгнээс бүрэн хамгаалагдсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална<br>5.3 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-3 ЦӨЦГИЙН ТОС /Масло/ Тоо хэмжээ: 800кг.

| № | СТАНДАРТ | Цөцгийн тос MNS 6652:2017 |
|---|---|---|
| 1 | Барааны ерөнхий шинж чанар | Цөцгийн тос нь цөцгийний өвөрмөц үнэр, амттай, гадны элдэв үнэр амтгүй, нэгэн жигд, цайвар шаргалаас шар өнгөтэй, тосны бүх хэсэгт алаг судалгүй. Нэгэн жигд нягт, уян налархай, зүсэлтийн гадаргуу нь гялалзсан, хуурай бөгөөд усны ил дусалгүй. |
| 2 | Савалгаа /кг/ | Савалгаа нь 20кг хүртэл картон хайрцагт савалгаатай байх. |
| 3 | Сав, баглаа, боодол | Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны ямар нэг бодис агуулаагүй, гадны үнэр, амтыг нэвтрүүлэхгүй байх. |
| 4 | Шошго, хаяглалт | “Савласан хүнсний бүтээгдэхүүний шошголтонд тавих ерөнхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:<br>„ үйлдвэрлэгчийн нэр хаяг, ялгах тэмдэг;<br>„ бүтээгдэхүүний нэр, зэрэг, дугаар;<br>„ бүтээгдэхүүний цэвэр жин, кг-аар;<br>„ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;<br>„ хадгалах хугацаа;<br>„ хадгалах нөхцөл;<br>„ стандартын дугаар, тэмдэглэгээ. |
| 5 | Дүгнэлт, шалгалт | Элсэн чихрийн чанар, аюулгүй байдал нь “ХӨӨЛГӨГЧ MNS(CAC)4293:1995” стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байх |
| 6 | Хадгалалт, Тээвэрлэлт | 6.1 Хөөлгөгч зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байна.<br>6.2 Хөөлгөгчийг агаарын солоилцоо сайтай -5$^0$С "аас дээшгүй дулаантай 60,-м дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй хортон шавьжаар бохирдоогүй, гадны элдэв үнэргүй, нар шороо чийгнээс бүрэн хамгаалагдсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална<br>6.3 Гүйцэтгэлийн хуваарьт заасан байршилд тухай бүрт нь тогтоосон хэмжээгээр хүргэнэ. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.
Багц№3 Бусад бүтээгдхүүн
Тоо хэмжээ: Цай-500 кг, Хөөлгөгч 100 кг, Давс- 1200 кг

| № | Багцын нэр, бүтээгдэхүүний нэр | Техникийн тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Цай | MNS (ISO)1572:2000, стандартыг хангасан байна. 1 ширхэг цай 1 кг-аар савлагдсан байна. Нийлүүлэх бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ үү. |
| 2 | Хөөлгөгч | Хөөлгөгч MNS(CAC)4293:1995 стандартыг хангасан байна.<br>Шаргал туяатай, саарaлдуу өнгөтэй, бараан толбогүй, хөгц ба гадны ямар нэгэн үнэргүй, гадны ямар нэг амтгүй, задлахад нунтаг байдалтай.<br>1 ширхэг Хөөлгөгч нь 500 гр савалгаатай байх. |
| 5 | Давс | MNS CAC150:2007 стандартыг хангасан, иоджуулсан 1 кг савалгаатай байна. |

# Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-2 ҮХРИЙН МАХ Тоо хэмжээ: 1100кг.

/хүзүү, сээр, нуруу, гуя, хаагаар нь салгаж махыг хүлээн авна/

Нийлүүлэгч нь өөрийн хөргүүртэй агуулахаас гэрээний хугацаанд өөрийн зардлаар хөргөлттэй автомашинаар хүргэж үйлчилнэ.

| № | СТАНДАРТ | MNS 1111:2007, MNS 5023:2001,CAC/RCP7:1974 |
|---|---|---|
| 1 | Шинж чанар | -Улаан ба хүрэн мах, цайвар шаргал өөхтэй,<br>-Тухайн махны өөрийн өвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудаагүй, гадны ямар нэгэн үнэргүй<br>-Цээжний хөндийд дотор эрхтэн болон цусны үлдэгдэлгүй, сэвс, шороо зэрэг гадны бохирдолгүй,<br>-H=5,4-5,8 |
| 2 | Зэрэглэл | MNS 1111:2007 стандартад заагдсан 1-р зэргийн шаардлага хангасан 120 кг-аас доошгүй жинтэй үхрийн мах |
| 3 | Тодорхойлолт | -Үхрийн тураг мах: Цусыг юүлж, толгой шийрийг салгаж, арьсыг өвчин, дэлэн, үржлийн эрхтэн болон цээжний ба хэвлийн хөндийгөөс дотор эрхтэнг салгаж авсны дараа үлдэх араг яс, булчин эд, гадар өөхнөөс бүрдэх гулууз мах.<br>-Үхрийн тал өрөөл мах: хүзүү, сээр, нуруу, өвчүүний дагуу ижил хэмжээтэй таллан хуваасан тураг махыг сээр нурууны 11,12 дугаар үений заагаар 11,12 дугаар хавирганы дундуур салгаж цээжний хэсэг, гуя сүвээний хэсэг болгон хуваасан мах. |
| 4 | Хяналт шалгалт | -Үйлдвэрийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна.<br>-Мах нэг бүрчлэн тухайн үйлдвэрийн дугаар бүхий тэмдэг дарсан байна. |
| 5 | Хүлээн авах | -Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүндээ мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ<br>-Эрүүл ахуйн аюулгүй байдлын тухай эрх бүхий лабораторийн шинжилгээ |
| 6 | Хадгалалт, Тээвэрлэлт | -Зориулалтын хөлдөөх төхөөрөмж бүхий зоорианд технологийн дагуу боловсруулалт хийн гүйцэд хөлдөөн хадгалах бөгөөд гүний температур нь -18С-ээс ихгүй байна.<br>-Хэрэгцээтэй үед тухай бүрт нь авч байна. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-2 ХОНИНЫ МАХ Тоо хэмжээ: 6500кг.

/махыг гулуузаар нь хүлээж авах ба бусад дайвар мах хамаарахгүй болно/

Нийлүүлэгч нь өөрийн хөргүүртэй агуулахаас гэрээний хугацаанд өөрийн зардлаар хөргөлттэй автомашинаар хүргэж үйлчилнэ.

| № | СТАНДАРТ | MNS 1111:2007, MNS 5023:2001,CAC/RCP7:1974 |
|---|---|---|
| 1 | Шинж чанар | -Улаан ба хүрэн мах, цайвар шаргал өөхтэй,<br>-Тухайн махны өөрийн өвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудаагүй, гадны ямар нэгэн үнэргүй<br>-Цээжний хөндийд дотор эрхтэн болон цусны үлдэгдэлгүй, сэвс, шороо зэрэг гадны бохирдолгүй,<br>-Н=5,4-5,8 |
| 2 | Зэрэглэл | MNS 1111:2007 стандартад заагдсан 1-р зэргийн шаардлага хангасан 18 кг-аас доошгүй жинтэй хонины мах |
| 3 | Тодорхойлолт | -Хонины гулууз мах: Цусыг юүлж, толгой шийрийг салгаж, арьсыг өвчин, дэлэн, үржлийн эрхтэн болон цээжний ба хэвлийн хөндийгөөс дотор эрхтэнг салгаж авсны дараа үлдэх араг яс, булчин эд, гадар өөхнөөс бүрдэх гулууз мах.<br>-Өрөөл мах: хүзүү, сээр, нуруу, өвчүүний дагуу ижил хэмжээтэй таллан хуваасан тураг махыг сээр нурууны 11,12 дугаар үений заагаар 11,12 дугаар хавирганы дундуур салгаж цээжний хэсэг, гуя сүвээний хэсэг болгон хуваасан мах. |
| 4 | Хяналт шалгалт | -Үйлдвэрийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна.<br>-Мах нэг бүрчлэн тухайн үйлдвэрийн дугаар бүхий тэмдэг дарсан байна. |
| 5 | Хүлээн авах | -Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүндээ мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ<br>-Эрүүл ахуйн аюулгүй байдлын тухай эрх бүхий лабораторийн шинжилгээ |
| 6 | Хадгалалт, Тээвэрлэлт | -Зориулалтын хөлдөөх төхөөрөмж бүхий зоорinternal технологийн дагуу боловсруулалт хийн гүйцэд хөлдөөн хадгалах бөгөөд гүний температур нь -18С-ээс ихгүй байна.<br>-Хэрэгцээтэй үед тухай бүрт нь авч байна. |

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-2 ЯМААНЫ МАХ Тоо хэмжээ: 4200кг.

/махыг гулуузаар нь хүлээж авах ба бусад дайвар мах хамаарахгүй болно/

Нийлүүлэгч нь өөрийн хөргүүртэй агуулахаас гэрээний хугацаанд өөрийн зардлаар хөргөлттэй автомашинаар хүргэж үйлчилнэ.

| № | СТАНДАРТ | MNS 1111:2007, MNS 5023:2001,CAC/RCP7:1974 |
|---|---|---|
| 1 | Шинж чанар | -Улаан ба хүрэн мах, цайвар шаргал өөхтэй,<br>-Тухайн махны өөрийн өвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудаагүй, гадны ямар нэгэн үнэргүй<br>-Цээжний хөндийд дотор эрхтэн болон цусны үлдэгдэлгүй, сэвс, шороо зэрэг гадны бохирдолгүй,<br>-Н=5,4-5,8 |
| 2 | Зэрэглэл | MNS 1111:2007 стандартад заагдсан 1-р зэргийн шаардлага хангасан 18 кг-аас доошгүй жинтэй хонины мах |
| 3 | Тодорхойлолт | -Ямааны гулууз мах: Цусыг юүлж, толгой шийрийг салгаж, арьсыг өвчин, дэлэн, үржлийн эрхтэн болон цээжний ба хэвлийн хөндийгөөс дотор эрхтэнг салгаж авсны дараа үлдэх араг яс, булчин эд, гадар өөхнөөс бүрдэх гулууз мах.<br>-Өрөөл мах: хүзүү, сээр, нуруу, өвчүүний дагуу ижил хэмжээтэй таллан хуваасан тураг махыг сээр нурууны 11,12 дугаар үений заагаар 11,12 дугаар хавирганы дундуур салгаж цээжний хэсэг, гуя сүвээний хэсэг болгон хуваасан мах. |
| 4 | Хяналт шалгалт | -Үйлдвэрийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна.<br>-Мах нэг бүрчлэн тухайн үйлдвэрийн дугаар бүхий тэмдэг дарсан байна. |
| 5 | Хүлээн авах | -Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүндээ мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ<br>-Эрүүл ахуйн аюулгүй байдлын тухай эрх бүхий лабораторийн шинжилгээ |
| 6 | Хадгалалт, Тээвэрлэлт | -Зориулалтын хөлдөөх төхөөрөмж бүхий зооринд технологийн дагуу боловсруулалт хийн гүйцэд хөлдөөн хадгалах бөгөөд гүний температур нь -18С-ээс ихгүй байна.<br>-Хэрэгцээтэй үед тухай бүрт нь авч байна. |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц-2 ДОТОР МАХ /Цувдай/ Тоо хэмжээ: 11000кг.

| № | Тавигдах шаардлага |
|---|---|
| 1 | MNS 1023-2007 –Дайвар бүтээгдэхүүн стандартыг хангасан байна.<br>-Бог малын зүрх, уушиг, бөөр, гүзээ, элэг, гэдэс дотор мах байна.<br>-Гэдэс дотрыг бүрэн цэвэрлэсэн.<br>-Муудаагүй, элдэв үнэргүй, дотор өөхгүй, шинээр нь бэлтгэн хөлдөөсөн байж болно.<br>-Зориулалтын сав баглаа боодолтой байна.<br>-Гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй байна. |

**Бараа нийлүүлэлтийн хуваарь**

| № | Барааны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг | Бараа нийлүүлэх хугацаа | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа *(Оролцогч энэ баганыг бөглөнө)* |
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* |
| 1 | *Мах махан бүтээгдэхүүн* | *4500* | *кг* | *БЗД 11-р хороо Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага* | *2025 оны 03 сарын 15-наас 2025 оны 12-31 хүртэл* | *]* |
| 2 | *Хүнсний ногоо* | *4300* | *кг* | *БЗД 11-р хороо Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага* | *2025 оны 03 сарын 15-наас 2025 оны 12-31 хүртэл* | |
| 3 | Бусад хүнсний материал | 12800 | кг | *БЗД 11-р хороо Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага* | *2025 оны 03 сарын 15-наас 2025 оны 12-31 хүртэл* | |

## V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1.Тендер илгээх маягт

Маягт 2.Барааны үнийн задаргаа

Маягт 3.Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1 **Тендер илгээх маягт** ***[огноо]***

***[Захиалагч байгууллагын нэр]***-д

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "**тендер**" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:

   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;

   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ***["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[30 ба түүнээс дээш хоногийн тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.[1]
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***

***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***

***албан тушаал, гарын үсэг,***

***байгууллагын тамга, тэмдэг]:*** ***Хаяг:***

---

Маягт 2 **Барааны үнийн задаргаа**

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Барааны нэр** | **Гарал үүслийн улс[2]** | **Тоо хэмжээ** | **Хэмжих нэгж, тун** | **Нэгж үнэ** | **Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)** | **Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ** | **Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж** | **Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)** | **Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх[3]** |
| 1 | | | | | | | | | | *Тийм/Үгүй* |
| 2 | | | | | | | | | | |
| … | | | | | | | | | | |
| | | | | | | | | **Тендерийн нийт үнэ** | | |

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***
***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***
***албан тушаал, гарын үсэг, байгууллагын***
***тамга, тэмдэг]:***

[2] ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.
[3] Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "тийм" гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 5 **Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

| |
|---|
| Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].* |

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |

Маягт 3 **Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
| --- | --- | --- | --- |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 4 **Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
| --- | --- | --- | --- | --- | --- |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Маягт 6 **Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

| | Нууцалсан баримт бичиг, мэдээлэл | Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл |
|---|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

# VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

**Санамж**

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.

1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;

1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;

1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. "Нийлүүлэгчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

**Бараа нийлүүлэх газар**

2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

**Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах**

2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.

2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.

**Барааг хүлээлгэн өгөх**

2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.

**Барааны гарал үүслийн улс**

2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.

